

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

200... оны ... -р сарын ... -ны (-ний) өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг МУ-ын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн

Нэг талаас **“МОННИС Интернэшнл” ХХК**, (цаашид **“Нийлүүлэгч тал”** гэх),
Ниссан төв, Нарны зам-13, 5-р хороолол, 2-р хороо, СБД, Улаанбаатар хот,
Утас: 318283, Факс: 323248

Нөгөө талаас (цаашид **“Худалдан авагч тал”** гэх),

Хаяг:

Утас: Факс:

нар (хамтад нь **“талууд”** гэх) харилцан тохиролцож дор дурдсан нөхцлөөр байгуулав.

Нэг. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

1.1. Гэрээний зүйл нь **“.....”** маркийн автомашин (цаашид **“Бараа”** гэх) бөгөөд дараах үзүүлэлтүүдтэй байна. Үүнд:

- | | | |
|--------|---------------------------|---------------|
| 1.1.1. | Тоо / Ширхэг: | / |
| 1.1.2. | Моделийн код: | |
| 1.1.3. | Аралын дугаар: | |
| 1.1.4. | Хөдөлгүүрийн дугаар: | |
| 1.1.5. | Хөдөлгүүрийн марк, төрөл: | |
| 1.1.6. | Кузовын өнгө: | |
| 1.1.7. | Хүч дамжуулагч: | |
| 1.1.8. | Үйлдвэрлэсэн огноо: | |

Хоёр. НИЙЛҮҮЛЭХ ХУГАЦАА, НӨХЦӨЛ

- 2.1. Барааг 200... оны ... -р сарын ... -ны (-ний) дотор **“Нийлүүлэгч”** талын **“Ниссан төв”**-д худалдан авагч талд хүлээлгэн өгнө.
- 2.2. Нийлүүлэгчийн буруугаас шалтгаалаагүй нийгэм, эдийн засгийн болон гэнэтийн буюу давагдашгүй нөхцөл байдлын улмаас барааг хугацаандаа нийлүүлээгүй бол нийлүүлэгч тал аливаа хариуцлага хүлээхгүй.
- 2.3. Худалдан авагч тал барааны төлбөрийг бүрэн төлж барагдуулсны дараа биет байдлаар болон өмчлөх эрхийг шилжүүлэн авна.
- 2.4. Барааг бодит байдлаар болон бичиг баримтыг хүлээлцсэн тухай акт хоёр хувийг үйлдэх бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг болно.

Гурав. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 3.1. Энэхүү гэрээний 1.1-д заасан барааны нэгжийн үнэ төгрөг (үсгээр) болно.
- 3.2. Энэхүү гэрээний 3.1-д заасан үнийг хямдруулан төгрөг байхаар тохиролцов.
- 3.3. Худалдан авагч нь барааны захиалга өгөх тохиолдолд барааны үнийн 20-оос доошгүй хувийг урьдчилан төлнө.
- 3.4. Худалдан авагч нь барааны үнийг 2009 оны ... -р сарын ... -ны (-ний) өдөр нийлүүлэгч талд төлнө.
- 3.5. Дээрх үнийн дүнд тээврийн зардал, импортын татвар, онцгой татвар, нэмэгдсэн өртгийн татвар, бусад зардлууд бүгд орсон болно.
- 3.6. Худалдан авагч нь гэрээнд заасан хугацаанд нийлүүлсэн автомашины үлдэгдэл төлбөрийг төлөөгүй тохиолдолд хоног тугамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0,3 хувийн алдангийг нийлүүлэгч талд төлнө.

Дөрөв. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Худалдан авагч нь энэхүү гэрээний 3.4-т заасан хугацаанд барааны төлбөрийг барагдуулах үүрэгтэй.
- 4.2. Нийлүүлэгч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй барааг худалдан авагч талд хүлээлгэн өгнө.
- 4.3. Нийлүүлэгч нь худалдан авагчийг урьдчилан захиалсан барааг худалдан авахаас татгалзсан тохиолдолд урьдчилан төлсөн үнийн дүнгийн 30 хувийг суутган, үлдсэн мөнгийг буцаан олгоно.
- 4.4. Нийлүүлэгч нь хүлээлцэх актаар хүлээлгэн өгч, өмчлөлд нь бүрэн шилжүүлсэн автомашиныг худалдан авагчаас буцааж авахгүй.
- 4.5. Худалдан авагч тал барааны баталгаат засварын хугацаанд зөв зохистой, гэрээний шаардлагын дагуу, зориулалтаар нь ашиглах үүрэгтэй.
- 4.6. Нийлүүлэгч нь барааг худалдагчийн өмчлөлд шилжүүлэх тухай албан тоот үйлдэж, Замын Цагдаагийн Газарт хүргүүлэх бөгөөд түүний хуулбар нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 4.7. Нийлүүлэгч нь мөнгөний ханшны өөрчлөлт, зах зээл дэх үнийн өсөлтөөс шалтгаалан барааны үнэд өөрчлөлт орохоор бол энэ тухай худалдан авагч талд нэн даруй мэдэгдэнэ.
- 4.8. Худалдан авагч нь 4.7-д заасан нөхцөл байдлын дагуу барааны үнэ өөрчлөгдсөн тохиолдолд барааг худалдан авахаас татгалзах эрхтэй.
- 4.9. Нийлүүлэгч нь худалдан авагчийг гэрээнд заасан хугацаандаа төлбөрөө төлөөгүй нэг сараар хэтрүүлвэл төлбөрөө бүрэн төлөх хүртэл автомашиныг үл маргах журмаар буцаан авах эрхтэй.

Тав. БАТАЛГАА

- 5.1. Нийлүүлэгч тал нь худалдсан автомашиндаа нэг жилийн буюу 25000 км-ийн баталгаа гаргаж өгөх бөгөөд уг хоёр нөхцлийн аль түрүүлж гүйцсэнээр тооцно.
- 5.2. Нийлүүлсэн автомашинд ашиглалтын явцад баталгаат хугацааны дотор эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд нийлүүлэгч талын Техникийн Хяналтын Комиссын /ТХК/ дүгнэлтэд үндэслэн засварын асуудлыг шийдвэрлэнэ. ТХК-н тогтоосноор тухайн эвдрэл, гэмтэл автомашин ашиглалтын хэвийн нөхцөлд илэрсэн тохиолдолд нийлүүлэгч тал гэмтлийг үнэ төлбөргүй засварлах буюу эд ангийг сольж өгнө.
- 5.3. Худалдан авагч нь баталгаат хугацаанд заавал хийлгэх ёстой тухайн үйлчилгээг зөвхөн Нийлүүлэгч талын авто засварын газарт тогтоосон үнэ, тарифын дагуу хийлгэж байна.
- 5.4. Баталгаат хугацаанд зайлшгүй хийлгэх техникийн үйлчилгээг хийлгээгүй, ний лүүлэгчээс өөр засварын газар, хувь үнээр засвар үйлчилгээ хийлгэсэн, эд ангийг сольж сэлгэсэн тохиолдолд баталгаа хүчингүй болно. Түүнээс үүдэн гарсан засварын зардлыг худалдан авагч тал хариуцна.
- 5.5. Автомашинаа байнга шалгах жолоочийнүүр гээ (тоормосны шингэн, тос, гидр, антифриз, автомат коробконы шингэний үвшин, дугуйны шпильк, хийн даралт г.м) биелүүлээгүйн улмаас гарсан эвдрэлийг худалдан авагч тал өөрөө хариуцна.
- 5.6. Баталгаанд автомашины амортизатор, пүрш, дугуй зэрэг явах эд ангийн эвдрэлүүд хамаарахгүй.

Зургаа. БУСАД ЗҮЙЛ

- 6.1. Талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2. Энэхүү гэрээг 2 хувь үйлдсэн бөгөөд эх тус бүр нь адил хүчин төгөлдөр байна.
- 6.3. Гэрээтэй холбоотой аливаа маргаан гарвал талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ бөгөөд боломжгүй гэж үзвэл шүүхэд хандан шийдвэрлүүлж болно.

Гэрээ байгуулсан:

Нийлүүлэгч тал:

Худалдан авагч тал: